

4. Бидний тухай, холбоо барих

Бидний тухай, төслийн бүтэц зохион байгуулалт

Нэн тэргүүнд Японы зөвлөх багийн гишүүдийг танилцуулах шаардлагатай болов уу. Уг баг нь 7 хүний бүрэлдэхүүнтэй ба гишүүн бүр өөр өөр чиглэлээр үүрэг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэх үүрэг	Гишүүдийн нэрс
Багийн дарга/Хатуу хог хаягдлын менежмент/Санхүүгийн менежмент 2	Ичино КОНО
Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	Кожин ЮЗАВА
Хог хаягдал цуглуулах ба тээвэрлэх	Жүнжи АНАИ
Ландфил менежмент	Хироши ФУЖИТА
Санхүүгийн менежмент 1	Сүсүмү ШИМУРА
Олон нийтийн мэдлэг, боловсрол	Юко АОКИ
Хог хаягдал ангилах ба дахин ашиглаж боловруулах	Миэ НАГАЯСУ
Зохицуулагч	Шиносүкэ ОДА

Төсөл хэрэгжүүлэгч Монгол талын байгууллага нь Улаанбаатар хотын ЗАА бөгөөд төслийн багт 10 ажилтан томилогдон ажиллаж байна.

Ажлын чиглэл	Гишүүдийн нэрс
1.Бодлого боловсруулах, төлөвлөлт	1. ОБХХМХ (С. Аригуун) 2. ХТГ (Н. Алтангэрэл),
2.Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ	1. ХТГ (Г. Дамдинсүрэн) 2. ОБХХМХ(Т. Энх-Амгалан) 3. Дүүргүүдийн ЗДТГ (*1)
3.НЭХЦ-ийн үйл ажиллагаа	1. ХТГ (В. Даваабаатар) 2. ОБХХМХ (Н. Ганбаатар)
4.Хог хаягдлын үйлчилгээний сан	1. ОБХХМХ (З. Мөнгөнзул) 2. Дүүргүүдийн ХХҮС (*2)
5.Олон нийтийн боловсролыг дээшлүүлэх.	1. ОБХХМХ (Е. Батбилэг) 2. Дүүргүүдийн ЗДТГ (*1)
6. Хог ангилах ялгах, дахин ашиглах/боловсруулах	1. EPWMD (O.Odjargal) 2. CMPUA (E.Iderchuluun)

*1: Одоогоор томилогдоогүй байгаа

*2: Цаашид үйл ажиллагаа нь үргэлжлэх нөхцөлд томилогдоно.

Өмнө дурьдсанчлан, хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулахын тулд холбогдох албан байгууллага, иргэдийн дунд нэгдсэн ойлголтыг бий болгох шаардлагатай байдаг. Энэ зорилгоор Монгол, Япон 2 тал харилцан зөвлөлдөж төслийн Хамтарсан зохицуулах хороо (ХЗХ)-г үүсгэн байгуулсан болно.

ХЗХ-г холбогдох байгууллагуудын хатуу хог хаягдлын асуудал хариуцсан албан тушаалтнуудаар бүрдүүлсэн ба уг хорооны үндсэн үүрэг нь төслийн явцыг хянаж, үр дүнг үнэлэх явдал юм. ХЗХ-ны гишүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

ХЗХ-ны гишүүд

Байгууллага	Газар/Хэлтэс
Сангийн яам	Зээл, тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газар
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар
Эрүүл мэндийн яам	Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
Улаанбаатар хотын ЗАА	Орчны бохирдол, хог хаягдлын менежментийн хэлтэс
Улаанбаатар хотын ЗАА	Хот тохижилтын газар
Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	
ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар	
ЖАЙКА-гийн Зөвлөх баг	
Япон улсаас Монгол улсад суугаа ЭСЯ	

Холбоо барих

ЯЗБ нь Хот тохижилтын газрын байранд байрлаж байгаа ба доор тэмдэглэсэн утас, факсаар бидэнтэй холбоо барьж болно.

ЯЗБ нь вэб сайт ажиллуулахаар төлөвлөж байгаа тул удалгүй бидэнтэй интернетээр харилцах боломжтой болно. Ингэснээр “Мэдээллийн тойм”-оос гадна вэб сайтаар дамжуулан төслийн явцыг танилцуулж байх юм. Мөн “Мэдээллийн тойм” болон холбогдох бусад баримт бичгийг интернетээс шууд татан авах боломжтой болно. Түүнчлэн, “Мэдээллийн тойм”-ыг цахим шуудангаар хүргэж байхаар төлөвлөж байгаа тул энэ үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаарх дэлгэрэнгүй зааврыг удалгүй та бүхэнд мэдэгдэх болно.

Нөгөө талаас, Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын өнөөгийн тогтолцооны талаарх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үзэл бодол, санал хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагаандаа тусган ажиллах шаардлагатай тул уншигч та төслийн талаарх үзэл бодол, санал хүсэлтээ “Мэдээллийн тойм”, вэб сайтаар дамжуулан бидэнтэй хуваалцаарай.

<p>ЖАЙКА-гийн Зөвлөх Баг Монгол улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх Техник, хамтын ажиллагааны төсөл</p> <p>[Ажлын байр] Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндын гудамж-68 Хот тохижилтын газрын байр Утас: 327128 Факс: 323128</p>



Мэдээллийн Тойм №. 1



Монгол Улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх техник хамтын ажиллагааны төсөл

Агуулга

1. Танилцуулга
2. Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын өнөөгийн байдал
3. Төслийн тойм
4. Бидний тухай, холбоо барих

1. Танилцуулга

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын хөгжлийн судалгааны хүрээнд 2007 онд боловсруулсан “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байгаа билээ.

Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийг шинээр байгуулж, улмаар өөрийн болон Японы буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хог тээврийн автомашин, хүнд даацын механизмыг худалдан авч бүрдүүлсэн.

Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээр хотын хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоонд дэвшил гарч байгаа боловч цаашид хийж сайжруулах зүйлс байсаар л байна. Тухайлбал хатуу



Нарангийн Энгэрийн Төвлөрсөн Хогийн Цэг

хог хаягдлын менежментийн салбарын бүтэц, тогтолцоонд хийгдсэн эрс өөрчлөлт болон “ЗР” зэрэг шинэ үзэл санааг нэвтрүүлэх болсноор холбогдох байгууллагууд, тэдгээрийн хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх шаардлага хурцаар тавигдаж байгаа юм.

“Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх” төсөл нь 2009 оны 10-р сараас эхлэн 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд уг төслийн хүрээнд Монгол талтай хамтран ажиллах Японы Зөвлөх Баг 10-р сарын 8-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотод ажиллаж байна.

Энэхүү товхимол нь төслийн явц, байдлыг уншигч таньд мэдээлж байдаг “Мэдээллийн Тойм”-ын анхны дугаар бөгөөд цаашид төсөл хэрэгжих хугацаанд тогтмол хэвлэгдэж байх юм.

2. Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн өнөөгийн байдал

Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөөний үндсэн зорилго нь “2020 оныг хүртэл хугацаанд байгаль орчинд ээлтэй хатуу хог хаягдлын менежментийг бүрдүүлэхэд” орших ба 3 үе шаттай хэрэгжүүлэх юм.

1 үе шат нь 2006-2010 онд хэрэгжүүлэх богино хугацааны зорилтууд байх ба эдгээрийг 2008 оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй харьцуулбал дараах зөрүүтэй байдал ажиглагдаж байна.

- Хотын хүн амын бодит өсөлт 2004 онд урьдчилан тооцоолсоноос хэт өндөр байгаа болно. Орон сууцны хорооллын хүн амын тоо төлөвлөсний дагуу өсөөгүй боловч гэр хорооллын хүн ам эрс өссөн байна.
- Хүн амын өсөлтөөс үүдэн гэр хороололд үүсч буй хог хаягдлын хэмжээ орон сууцны хорооллынхоос хоёрд дахин их байгаа тул хотын хэмжээнд үүсэх хог хаягдлын нийт хэмжээ нь урьдчилан тооцоолсноос хавьгүй илүү байх төлөвтэй байна.
- Хог хаягдлыг дахин ашиглах болон дахин боловсруулах чиглэлээр тодорхой амжилтанд хүрээгүй байна.

Энэхүү төслийн хэрэгжүүлэхийн өмнө мастер төлөвлөгөөнд заасан зорилтуудын биелэлтийг тогтоож, төлөвлөсөн түвшинд хүрээгүй шалтгааныг нарийн тодруулах шаардлагатай байгаа юм.



Хог тээврийн автомашин

3. Төслийн тойм

Техник хамтын ажиллагааны аливаа төслүүд нь ЖАЙКА-гийн гадаад үйл ажиллагааны үндсэн хэлбэр юм.

Эдгээр нь бодит үр дүнд чиглэсэн байх ба гол төлөв 2 улсын мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, туршлагад үндэслэн тодорхой асуудлыг тогтоосон хугацаанд шийдвэрлэх зорилготой байдаг. Энэ нь Япон улсаас мэргэжилтэн ирүүлэх, Монгол талын боловсон хүчнийг Япон улсад сургалтанд хамруулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх зэргээр хэрэгждэг. Техник, хамтын ажиллагааны төслүүдийг Монголын талтай харилцан зөвлөлдөж тус улсын нөхцөл байдалд нарийн тохируулж төлөвлөдөг ба 2 тал хамтран хэрэгжүүлдэг.


¹2001 онд батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”

Төслийн үүрэг, ач холбогдол

Улаанбаатар хотын ЗАА нь хөгжлийн судалгааны хүрээнд боловсруулсан мастер төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагуудыг өөрчилж, хүчин чадлыг нь бэхжүүлэх, хатуу хог хаягдлын менежментийн бүтцийг өөрчлөх, санхүүгийн тогтолцоог шинэчлэх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Мөн санхүүгийн зарим эх үүсвэрийг ашиглан төвлөрсөн хогийн цэгийг шинээр барьсан, хог тээврийн автомашины паркийг шинэчилсэн, ландшафтын зориулалт бүхий хүнд механизмыг бүрдүүлсэн зэрэг хог хаягдлын салбарын дэд бүтцийг сайжруулах олон ажлыг хийж гүйцэтгэжээ.

Энэхүү төсөл нь хог хаягдлын менежментийн салбарт бий болсон өнөөгийн тогтолцоо, дэд бүтэц, санхүүгийн систем болон холбогдох байгууллагуудын чадавхийг бүрэн ашиглах замаар Улаанбаатар хотын ЗАА-нд "Байгаль орчинд халгүй хатуу хог хаягдлын менежментийг бүрдүүлэх" зорилгоо биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Төслийн ерөнхий зорилт бол хатуу хог хаягдлын менежментийн зохисгүй тогтолцооноос үүдэн орчны бохирдол, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах явдал юм.

Хөгжлийн судалгаанаас эхлэн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр ЖАЙКА, Улаанбаатар хотын ЗАА-наас хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон энэхүү техник, хамтын ажиллагааны төслийн гүйцэтгэх үүргийг дараах бүдүүвч зургаар үзүүлэв.



Төслийн тоймыг дараах байдлаар танилцуулж байна.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Гэрээ	1 жил				2 жил				3 жил																
	2009				2010				2011				2012												
СЖ	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9
Хуанли	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9
Монгол дахь ажил	[A] 1-р жил монголд				[B] 2-р жил монголд				[C] 3-р жил монголд																
Япон дахь ажил	[0] Бэлтгэл ажил Японд																								
Семинар					3R(1)				Аюултай хаягдал				3R(2)				Бусад хотод зохион байгуулах семинар 3R(3)				ТЭТ				
Бага хурал					ХХҮС(1)				ХХҮС(2)				Т/т-ийн үйлчилгээ				ХХҮС(3)								

Зорилго

Төсөл хэрэгжүүлэх үндсэн зорилго нь Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэхэд оршино.

Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн

Төслийг хэрэгжүүлснээр дор дурьдсан 6 үр дүн гарах болно.

Үр дүн 1: Хатуу хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, боловсруулах талаар бодлого боловсруулах, төлөвлөлт хийх чиглэлээр ЗАА-ны Орчны бохирдол, хог хаягдлын менежментийн хэлтэс (ОБХХМХ)-ийн хүний нөөцийн чадавхи дээшилнэ.

Үр дүн 2: Хог тээврийн автомашин, хүнд механизмын ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр Хог тохижилтын газар (ХТГ), ОБХХМХ-ийн хүний нөөцийн чадавхи дээшилнэ.

Үр дүн 3: Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэг (НЭХЦ)-ийг зохистой ашиглах чиглэлээр ХТГ-ын хүний нөөцийн чадавхи дээшилнэ.

Үр дүн 4: Хатуу хог хаягдлын менежментийн санхүүгийн удирдлага, менежментийн чиглэлээр ОБХХМХ болон Хог хаягдлын үйлчилгээний сан (ХХҮС)-гийн хүний нөөцийн чадавхи дээшилнэ.

Үр дүн 5: Хатуу хог хаягдлын менежментийн үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг оролцуулах, тэдгээрийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ОБХХМХ болон дүүргүүдийн ЗДТГ-ын хүний нөөцийн чадавхи дээшилнэ.

Үр дүн 6: Улаанбаатар хотод хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, боловсруулах хамгийн тохиромжтой тогтолцооны талаар иж бүрэн мэдээлэл бий болно.

Хамрах хүрээ

Улаанбаатар хот (6 дүүрэг: Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх)

Хамрагдах хог хаягдлын төрөл

Хотын хатуу хог хаягдал (өрхийн түвшинд үүсч байгаагаас бусад аюултай хог хаягдлыг хамруулахгүй)

Төсөл хэрэгжүүлэх бүтэц

Төслийн захирал: Улаанбаатар хотын Ерөнхий Менежер

Төслийн менежер: Нийслэлийн ЗАА-ны ОБХХМХ-ийн дарга


Хамтрагч байгууллагууд: ОБХХМХ, ХТГ, Дүүргүүдийн ЗДТГ, ХХҮС-гууд.

Нэмэлт сэдэв: Хог хаягдал гэж юу вэ?

Хог хаягдал нь бидний өдөр тутмын амьдралаас үүсэн бий болдог билээ. Хог хаягдлыг бид өөрсдөө үүсгэдэг боловч үнэн хэрэгтээ өдөрт хэдий хэмжээний хог үүсдэг, хэрхэн тээвэрлэдэг, төвлөрсөн хогийн цэг дээр хэрхэн дарж булдаг талаар нарийн зүйлсийг тэр бүр мэддэггүй. Учир иймд энэхүү "Мэдээллийн тойм"-оороо дамжуулан уг салбарын тогтолцооны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг цуврал хэлбэрээр хүргэж байхаар боллоо.

Хог хаягдал нь үүссэн цагаасаа эхлэн төвлөрсөн цэг дээр дарж булагдах хүртлээ хэд хэдэн шатыг дамждаг. Дамжлага бүрт холбогдох мэдээллийг хог хаягдлын урсгалыг ашиглан дараах бүдүүвч зургаар тайлбарлаж болдог.

Хотын хатуу хог хаягдлын урсгал



1. Хог хаягдал үүсэх

Хог хаягдал бол хүний үйл ажиллагаанаас үүсэн гарч буй хэрэгцээгүй эд зүйлс юм.² Өөрөөр хэлбэл хүн аж төрж байгаа цагт хог хаягдал үүссээр байх болно. Энэ нь хог хаягдлын менежментийн үндсэн ойлголт ба хог хаягдлын тогтвортой менежментийг бий болгоход анхаарвал зохих чухал үе шат болдог.

Эдийн засаг, материаллаг нийгмийн хөгжлийг дагаад хог хаягдлын хэмжээ мөн өссөөр байна. Өндөр хөгжилтэй улсуудад их хэмжээний үйлдвэрлэл, өргөн хэрэглээнд тулгуурласан амьдралын хэв маягт шүүмжлэлтэй хандах болж, улмаар хог хаягдлыг бага үүсгэдэг нийгмийг цогцлуулахаар зорих болжээ.

Тэгвэл "Нүүдлийн соёл"-д түшиглэсэн Монголын уламжлалт амьдралын хэв маяг нь хог хаягдлыг маш багаар үүсгэдэг ба ингэж үүссэн хог хаягдал нь богино хугацаанд задран хөрсөнд шингэдэг байна. Энэ утгаараа Монголын ард түмний уламжлалт хэв маяг нь байгаль экологид хамгийн ээлтэй амьдралын хэв маяг байжээ. Энэ нь нүүдлийн амьдралдаа эргэн ор гэсэн үг биш, харин өвөг дээдсийнхээ амьдрах арга барилыг хүндэтгэн үзэх нь чухал гэсэн санаа юм.

2. Хадгалах

"Хог хадгалах" гэдэг нь үгийн хувьд тийм ч ойр санагдахгүй байж болох юм. Энэ нь хогийг гаргаж хаях хүртэл гэрийнхээ болон албан өрөөнийхөө, цаашилбал дэлгүүр, ресторан зэрэгт байрлуулсан хогийн саванд байлгаж байхыг хэлдэг.

Энэ нь гудамж, зам, талбай зэрэг нийтийн эзэмшлийн газар, хүний амьдралын орчинг цэвэр байлгахад зайлшгүй шаардлагатай үе шат юм. Хамгийн чухал нь ачиж, тээвэрлэх хүртэл хог хаягдлыг нийтийн эзэмшлийн газарт удаан байлгхааас зайлсхийж, аль болох гэрийнхээ болон хувийн эзэмшлийн газарт тань байрлах зориулалтын сав, байгууламжинд хадгалж байх явдал юм.

Бункер бүхий байрнууд Улаанбаатар хотод элбэг байдаг ба ийм байрны оршин суугчид хогоо гэртээ хадгалах шаардлагагүй, хүссэн цагтаа гаргаж хаях боломжтой байдаг. Бункерийн систем нь хэдийгээр оршин суугчдад амар байдаг ч, нөгөө талаас нь аваад үзвэл бункерт удсан хог нь (ялангуяа зуны цагт) ялзарч үмхийрэн тухайн орчин нь эрүүл ахуйн наад захын шаардлагыг хангахгүй болдог ба гал гарах ч тохиолдол байдаг. Тийм учраас өндөр хөгжилтэй оронд бункерийн систем бүхий орон сууцнаас аль хэдийнэ татгалзах болсон.

Хогийг ачиж, тээвэрлэх хүртэл гэртээ, өөрийн эзэмшил газартаа хадгалж, улмаар нийтийн эзэмшил газарт байх хугацааг нь богиносгохын тулд хог тээврийн үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол гүйцэтгэдэг байх нь нэн чухал.

А. Дахин ашиглах/Дахин боловсруулах

(Хаяхын өмнөх ангилан ялгалт)

Хогийг гаргаж хаяхдаа дахин ашиглаж болох эд зүйлсийг ялгах процессыг "хаяхын өмнөх ангилан ялгалт" гэдэг. Долоо хоногийн аль нэг өдөрт зөвхөн энэ төрлийн хог хаягдлыг авдаг байхаар нэмэлт үйлчилгээг алсдаа нэвтрүүлэх болно. Энэ нь дахин ашиглах боломжтой хогийг иргэдийн оролцоотойгоор сэргээн ашиглах хамгийн үр дүнтэй арга байдаг. Төвлөрсөн хогийн цэг дээр хог түүгчдээр дамжин хэрэгжиж буй ангилан ялгалттай харьцуулбал хаяхын өмнөх ялгалт нь эрүүл ахуйн талаасаа шаардлага хангасан, хавьгүй аюулгүй ажиллагаа байдаг.

Бид 2006 онд Чингэлтэй дүүргийн 3-р хороонд туршилтын төслүүд хэрэгжүүлж, энэ системийг хотын хэмжээнд нэвтрүүлэх боломжтойг баталсан юм. Хаяхын өмнөх ангилан ялгалт нь энэхүү төслийн үндсэн зорилтуудын нэг тул дараа дараагийн дугааруудаар илүү дэлгэрэнгүй танилцуулах болно.

---Хог хаягдлын менежментийн бусад үе шатуудын талаар дараагийн дугаараас үзнэ үү

² Дэлхийн банкнаас гаргасан тайлбар тодорхойлолт